

**Эрүүл мэндийн салбарын нээлттэй мэдээллийн ил тод байдлын
хэрэгжилтэд 2025 оны байдлаар хийсэн хяналт-шинжилгээ,
үнэлгээний танилцуулга**

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу Эрүүл мэндийн салбарын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд 2025 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газартай хамтран хийв.

Үнэлгээнд Эрүүл мэндийн яамны харьяа агентлагууд, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд, тусгай мэргэжлийн төвүүд, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд болон бусад эрүүл мэндийн байгууллагууд, нийт 24 байгууллагыг хамруулсан.

Үнэлгээг хийхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан өөрт хамаарах нээлттэй мэдээллийг тухайн байгууллагууд албан ёсны цахим хуудсандаа бүрэн байршуулсан эсэх, мэдээллийг хугацаанд нь шинэчилж байгаа эсэх, мэдээллийн эх сурвалж тодорхой эсэх зэрэг үзүүлэлтүүдийг “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан шалгуурын дагуу үнэлсэн болно. Үүний зэрэгцээ нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулсан мэдээлэлтэй тулган харьцуулалт хийсэн болно.

Үнэлгээг журмын дагуу дараах чиглэлээр хийсэн. Үүнд:

1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал;
2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал;
3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал;
4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал;
5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал.

Эрүүл мэндийн салбарын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 2025 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 52.1 хувьтай байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээний түвшин харилцан адилгүй байгаа бөгөөд хамгийн өндөр үзүүлэлт 87.5 хувь (Улсын гуравдугаар төв эмнэлэг), хамгийн бага нь 30.2 хувь (Дорнод аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв), цахим хуудас ажиллахгүй буюу 0 хувь (Өмнөговь аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв)-тай байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг Хүснэгтэд харуулав.

Үнэлгээг хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдлууд илэрсэн. Үүнд:

- Мэдээлэл хариуцагч байгууллагууд нээлттэй мэдээллийг хэлбэр төдий байршуулах, мэдээлэл дутуу, бүрэн бус байх, хугацаанд нь шинэчилдэггүй;

- Байгууллагын эрхэм зорилго, стратегийн зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлийг байршуулсан боловч тэдгээрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэл, тайланг ил тод байршуулахгүй байгаа;

- Байгууллагын цахим хуудсанд мэдээллийг иргэнд ойлгомжгүй, хайлт хийхэд хүндрэлтэй байдлаар байршуулсан;

- Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл, тайланг байршуулдаггүй;

- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэлд төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны талаарх тайлбар дутуу;

- Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулдаггүй, тухай бүр шинэчилдэггүй;

- Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж болон төлбөр төлөх дансны мэдээлэл хангалтгүй;

- Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг бүрэн байршуулдаггүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангаар хязгаарлаж байгаа;

- Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газар, оюуны өмчийн мэдээлэл, барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт, мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл байршуулдаггүй;

- Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайлан, албан тушаалын тодорхойлолтыг бүрэн байршуулдаггүй, тухай бүр шинэчилдэггүй.

Салбарын хэмжээнд нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/352 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам, байгууллагын цахим хуудсанд байршуулах нээлттэй мэдээллийн жагсаалт”, мөн Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/93 дугаар тушаалаар холбогдох журмыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Хүснэгт. Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээ, 2025 он

№	Байгууллагын нэр	Shilen.gov.mn 2025.06	Эрүүл мэндийн яамны үнэлгээ
1	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	97.0	69.3
2	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	74.0	48.3
3	Эрүүл мэндийн хөгжлийн төв	0	53.7
4	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	0	58.8
5	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	0	30.9
6	Улсын гуравдугаар төв эмнэлэг	0	87.5
7	Халдварт өвчин судлалын үндэсний төв	0	58.5
8	Хавдар судлалын үндэсний төв	35.0	79.6
9	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	0	51.3
10	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II	0	54.9
11	Гэмтэл согог судлалын үндэсний төв	67.0	65.6
12	Арьсны өвчин судлалын үндэсний төв	0	56.0
13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	0	42.8
14	Геронтологийн үндэсний төв	0	46.3
15	Хүүхдийн төв сувилал	0	63.4
16	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	0	54.5
17	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	0	66.2
18	Эмгэг судлалын үндэсний төв	0	62.6
19	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	0	47.1
20	Дорнод аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	13.0	30.2
21	Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	0	42.2
22	Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	33.0	38.0
23	Өмнөговь аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	0	0
24	Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	0	43.1
Үнэлгээний дундаж		13.3	52.1

Дүгнэлт

Эрүүл мэндийн салбарын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 2025 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 52.1 хувьтай байгаа нь хангалтгүй түвшинд байгаа хэдий ч энэ нь 2025 оны хагас жилийн дундаж үнэлгээ (13.3%)-нээс эрс сайжирсан үзүүлэлт юм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад мэдээллийг бүрэн, үнэн зөв, хугацаанд нь шинэчлэн байршуулах, иргэнд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх шаардлага салбарын хэмжээнд нэлээд их байна.

Түүнчлэн байгууллагууд мэдээллийг хэлбэр төдий байршуулах, тайлагналтын чанар сул, мэдээллийн агуулга дутуу, шинэчлэлт тогтмол бус зэрэг нийтлэг зөрчил давамгайлж байна. Ялангуяа стратеги, бодлогын хэрэгжилтийн үр дүн, төсөв, санхүүгийн ил тод байдал, үйлчилгээний мэдээллийн бүрдэл дутмаг байгаа нь анхаарал татаж байна.

Иймд цаашид нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг байгууллагын үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон төлөвшүүлж, мэдээллийн чанар, бүрдэл, шинэчлэлтийг сайжруулах, цахим хуудсын хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын хариуцлага, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мөн үнэлгээний аргачлалыг нэгдсэн ойлголттой болгон боловсронгуй болгох шаардлагатай байна.

Зөвлөмж

Цаашид байгууллагууд албан ёсны цахим хуудсаа тогтмол ажиллуулж, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, хугацаанд нь хийж, мэдээллийг үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой байдлаар байршуулахад онцгой анхаарах шаардлагатай байна. Мөн албан хаагчдын хариуцлага, идэвх санаачлагыг нэмэгдүүлж, удирдлагын зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Түүнчлэн нээлттэй мэдээллийг байршуулах чиглэлээр албан хаагчдад зориулсан сургалтыг тогтмол, тасралтгүй зохион байгуулж, шинэчилсэн мэдээллээр тухай бүр хангаж ажиллах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн яам
2026 оны 03 дугаар сар